



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 1159

Ховд

Баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэг, Үндэсний Их баяр наадам зохион байгуулах хорооны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2233, Их Монгол Улсын 818, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой, аймгийн баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, байгаль цаг үеийн онцгой нөхцөлийг харгалзан Зэрэг, Дарви сумын баяр наадмыг 07 дугаар сарын 01-03-ны өдөр, Мянгад сумын баяр наадмыг 07 дугаар сарын 06-ны өдөр, бусад сумдын баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Аймаг, сумдын баяр наадмыг зохион байгуулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг холбогдох сум, байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгасугай. Үүнд:

2.1 Баяр наадмын бэлтгэл ажлыг сайтар хангаж, нийтийн хэв журмын зөрчилгүй, унаач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, баяр наадмыг зохион байгуулах хороо, салбар хороодод;

2.2 Баяр наадмын үеэр болон амралтын өдрүүдэд байгууллага бүр хариуцлагатай жижүүр томилон ажиллуулахыг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт;

2.3 “Цэвэрхэн, хоггүй наадацгаая” уриалгыг хэрэгжүүлж, наадмын арга хэмжээний дараа зам, талбай, морины барианы газрын цэвэрлэгээнд идэвхтэй оролцохыг бүх шатны төрийн албан хаагчдад үүрэг болгож, ард иргэдэд зөвлөмж болгон хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт;

8400001-1126

ZahA459 Ba

3. Захирамжийг сум, байгууллагад шуурхай хүргүүлж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД